

НИСЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД, СЭРГЭЭН ЗАСАХ АЛБАНЫ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.06.17

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн “Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 05/22 тоот удирдамжийн хүрээнд Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах амралтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, аудитор А.Мөнх-Эрдэнэ, О.Сэндэр, Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах амралтын 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны касс, харилцах дансны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, бараа материалын бүртгэл зэргийг нягталж шалгахаас гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

НЭМСЗА нь Үндэсний архивын газрын даргын 2007 оны “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, ИНЕГ-ын даргын 2016 оны А/415 дугаар тушаалаар баталсан “Архивын ажлыг эрхлэн хөтлөх заавар”-ыг мөрдөж ажиллаагүй, ажлын хариуцлага, мэдлэг хангалтгүй байна.

НЭМСЗА (тухайн үеийн нэрээр СЗА)-ны үйл ажиллагаанд 2021 оны 12 дугаар сард ИНЕГ-ын даргын 31/21 дугаартай удирдамжийн дагуу хэсэгчлэн хийсэн дотоод, аудит хяналт шалгалтаар нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт хангалтгүй байсан зөрчил 2022 оны эхний 4 сарын байдлаар давтагдан гарсан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээг санхүүгийн тайланд тусгасан.

Үндэсний аудитын газраас 2021 онд Сэргээн засах алба (Тухайн үеийн нэрээр)-ны 2020 оны Санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Зөрчил арилгах тухай” 476/А0170067 дугаартай албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар төлөвлөгөө гаргасан, удирдах дээд байгууллагадаа албан бичиг явуулсан зэрэг ажил 2020, 2021 онын эхний хагаст хийгдэж тодорхой хэмжээгээр буурч эхэлсэн боловч 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний улиралд ажил хийгдээгүй байгаагаас авлагын дүн өссөн байна.

НЭМСЗА-ны бараа материалын бүртгэл хөтлөлтийг шалгахад ИНЕГ-ын НБББББ-ийн Бараа материалын бүртгэлд ашиглах анхан шатны баримтуудаас 2021 он, 2022 оны эхний улирлын байдлаар баримтуудын бүрдэл хангалтгүй. Мөн ИНЕГ-ын НБББББ-ын 4.3-т заасан Бараа материалын бүртгэлийн А-д заасан бараа материалын гүйлгээг бүртгэх журналын бичилтийг зөрчиж 2022 оны эхний 5 сард 12 ажил гүйлгээнд 49.5 сая төгрөгийн худалдан авалтад НӨАТ-ын авлага үүсгээгүй зөрүүтэй бүртгэсэн.

СЗА (тухайн үеийн байдлаар)-ны 2021 онд нийт 329.9 сая төгрөгийн бараа, материал худалдан авснаас 16.4 сая төгрөгийн НӨАТ-ын авлага үүссэн. Энэ нь нийт 163.8 сая төгрөгийн бараа материалыг НӨАТ төлөгч байгууллагаас худалдан авсан нь нийт



худалдан авалтынхаа 50 орчим хувийг НӨАТ-тэй газраас хийсэн буюу ИНЕГ-ын системийн хэмжээнд төлөх НӨАТ-аас хасагдах татварт тооцогдсон.

2021 онд тус амралтын 9 ажилтны нэр дээр 5.6 сая төгрөгийн, 2022 оны эхний 5 сарын байдлаар 0.7 мянган төгрөгийн орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягт, заавар, ИНЕГ-ын НБББББ-ийг бүхэлд нь зөрчсөн.

Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах албаны 2022 оны 1 дүгээр улирлын орлогын дансанд бүртгэгдсэн НӨАТ-ын өглөгийг зөрүүтэй бүртгэсэн.

Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах албаны 2022 оны 1 дүгээр улирлын нийт орлогын дансанд НӨАТ-ын өглөгийн бүртгэлийг шалгахад НӨАТ ногдох борлуулалтын орлогын дүн 12.1 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн.

Тус албаны 2022 оны 1 дүгээр улирлын гэр орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэл, ногдуулсан татварыг шалгахад гэр орлогод нийт 22.0 сая төгрөгийн орлоготой ажилласнаас 16.5 сая төгрөгийн орлогод НӨАТ-ын өглөг тооцсон буюу 5.5 сая төгрөгийн орлогыг алдаатай бүртгэсэн НӨАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.8-д заасныг зөрчсөн.

Тус албаны 2021 оны 1-4 дүгээр улирал болон 2022 оны 1 дүгээр улирлын орлогод нийслэл хотын албан татвар ногдуулсан байдлыг шалгахад 2021 он, 2022 оны НХАТ ногдох орлогоос бага дүнгээр тайлагнасан байна.

НЭМСА-ны 2022 оны худалдан авах ажиллагааг шалгахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д заасан худалдан авах төлөвлөгөө боловсруулаагүй.

НЭМСЗА-ны 2021, 2022 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хугацаа хоцроодог, мэдээллийг үнэн зөв, иж бүрэн хийгээгүй, хөрөнгө мөнгө захиран зарцуулах шийдвэр мэдээлээгүй, зарлагын гүйлгээнд шийдвэрийн хуулбар оруулаагүй, орон тооны мэдээлэл зөрүүтэй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дотоод аудитын албанаас 2021 оны 12 дугаар сард ИНЕГ-ын даргын 31/21 дугаартай баталсан удирдамжийн дагуу хийсэн дотоод аудит хяналт, шалгалтаар нийт 15 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн хэрэгжилт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 78 хувьтай хангалтгүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Нисэхийн эрүүл мэнд сэргээн засах албанд 17 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА